

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 05 дугаар сарын 01

Тендер шалгаруулалтын нэр: **Дулааны сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн, Төв зах, Гурван-Эрдэнэ сургууль, Зүүн талын шинэ хороолол/-ийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХААГ-А-2013/ХҮIII-15**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг **Худалдан авах ажиллагааны газар** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“Дулааны сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн, Төв зах, Гурван-Эрдэнэ сургууль, Зүүн талын шинэ хороолол/-ийн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил”-ыг** гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **200,000 (хоёр зуун мянган)** төгрөгийг тушаан худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын аль нэг жил нь санал болгож буй үнийн дүнгийн 50%-с доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу 2010, 2011, 2012 он.

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 5 жилийн аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

- **Зураг төсөл боловсруулах байгууллага нь:**

1.3.1: Дулааны шугам гол сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг боловсруулах Тусгай зөвшөөрөлтэй байх.

- **Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:**

03.5.1: 115-250°C температуртай, 16.0-40.0 кгх/см2 даралттай дулааны шугам хоолой, ЦТП-ны угсралт, засвар, туршилт тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт **50,000,000 (тавин сая)** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2013 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 15:00 цагаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2013 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 15 цаг 30 минутад нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй.**

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

14193 Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Их тойруу 80/1

Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 70111090, 70125060

www.e-tender.mn, www.procurement.gov.mn

www.e-procurement.mn